



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2021/2/СТА-ТШЗ

Баянхонгор 2021 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhatb@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням Утас: 88089024 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: П.Амаржаргал Утас: 88106992 Цахим хаяг: amarjargalp@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт /эх хувь/	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	11
3.Аудитын тайлан	11
3.1. Ерөнхий зүйл	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	12
3.4. Материаллаг байдал	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	14
3.7. Шилэн дансны мэдээлэл	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	16



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА М.МАЙЖАРГАЛ
ТАНАА

2021. 02.10 № 2/25

танай _____ -ны № _____ -т

Г **Аудитын гэрчилгээ** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын

2021 А4 ТООТ



бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨДТӨРГҮҮДЭХ
АУДИТОР  Б.МӨНХБАТ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	30,469,424.00	30,517,136.00
33	АВЛАГА	00.00	80,011.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	80,011.00
35	БАРАА МАТЕРИАЛ	30,469,424.00	30,437,125.00
354	Хангамжийн материал	30,469,424.00	30,437,125.00
35410	Бичиг хэргийн материал	4,184,146.00	3,755,696.00
35420	Аж ахуйн материал	23,969,978.00	24,750,758.00
35440	Түлш, шатах тослох материал	990,000.00	605,371.00
35470	Бусад хангамжийн материал	1,325,300.00	1,325,300.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	553,408,873.39	543,765,316.61
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	553,408,873.39	543,765,316.61
392	Биет хөрөнгө	490,747,073.47	480,225,566.74
39201	Барилга, байгууламж, орон сууц	488,335,355.19	488,335,355.19
39202	Хуримтлагдсан элэгдэл	-54,824,644.33	-76,863,206.65
39203	Авто-тээврийн хэрэгсэл	78,936,000.00	78,936,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-76,686,000.00	-77,436,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	155,714,668.01	177,562,068.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	-136,227,121.35	-145,721,436.91
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	90,758,235.12	98,106,235.12
39208	Хуримтлагдсан элэгдэл	-58,005,779.17	-65,453,648.02
39214	Бусад үндсэн хөрөнгө	189,400.00	189,400.00
39217	Ном	2,556,960.00	2,570,800.00
393	Биет бус хөрөнгө	62,661,799.92	63,539,749.87
39301	Программ хангамж	891,000.00	1,891,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-750,200.08	-872,250.13
39303	Бусад биет бус хөрөнгө	62,521,000.00	62,521,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	583,878,297.39	574,282,452.61
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	80,011.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	80,011.00
413	Өглөг	00.00	80,011.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	80,011.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	583,878,297.39	574,202,441.61
51	Засгийн газрын хувь оролцоо	583,878,297.39	574,202,441.61
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	818,720,719.00	818,720,719.00
51101	Өмч: - төрийн	818,720,719.00	818,720,719.00
512	Хуримтлагдсан үр дүн	-273,454,612.37	-283,130,468.15
51210	Өмнөх үеийн үр дүн	-273,454,612.37	-273,454,612.37
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-9,675,855.78
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	38,612,190.76	38,612,190.76
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	583,878,297.39	574,282,452.61

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	957,351,367.00	1,048,860,320.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,181,867.00	21,085,420.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,181,867.00	21,085,420.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,181,867.00	20,157,740.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5181867.00	20157740.00
120009	Бусад орлого	1,221,300.00	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө	3,960,567.00	20,157,740.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Бараа материал	00.00	927,680.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	952,169,500.00	1,027,774,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	952,169,500.00	1,014,274,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	952,169,500.00	1,014,274,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	13,500,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	10,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	3,500,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	983,450,985.09	1,058,536,175.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	983,450,985.09	1,058,536,175.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	974,933,280.38	1,005,027,490.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	748,630,621.29	759,374,430.00
210101	Үндсэн цалин	634,092,880.29	611,867,023.00
210102	Нэмэгдэл	72,251,143.00	99,031,949.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,425,314.00	24,336,000.00
210104	Урамшуулал	20,861,284.00	24,139,458.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,716,687.55	95,306,030.00
210201	Тэтгэврийн даатгал	56,840,587.00	66,319,580.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,469,000.55	7,855,313.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,437,055.00	5,609,905.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,031,945.00	1,440,667.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,938,100.00	14,080,565.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,630,000.00	39,136,062.00
210301	Гэрэл, цахилгаан	4,984,609.00	4,555,650.00
210302	Түлш, халаалт	32,928,708.00	32,362,800.00
210303	Цэвэр, бохир ус	2,716,683.00	2,217,612.00
2104	Хангамж, бараа материалын зардал	46,200,650.00	47,097,035.00
210401	Бичиг хэрэг	12,632,000.00	13,733,430.00
210402	Тээвэр, шатахуун	16,410,000.00	12,754,629.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,328,840.00	12,768,998.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,589,810.00	7,239,978.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,316,180.00	5,531,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	907,980.00	216,600.00
210604	Урсгал засвар	6,408,200.00	5,314,900.00
2107	Томилолт, зочны зардал	5,094,150.00	5,078,000.00
210702	Дотоод албан томилолт	5,094,150.00	5,078,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,558,867.00	13,651,637.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	609,621.00	11,982,437.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	847,000.00	847,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	141,746.00	154,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	247,500.00	00.00
210807	Газрын төлбөр	369,000.00	323,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,786,124.54	39,852,796.78
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	37,786,124.54	39,852,796.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,517,704.71	53,508,685.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,990,000.00	3,968,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,990,000.00	3,968,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,527,704.71	49,540,685.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,527,704.71	49,540,685.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-26,099,618.09	-9,675,855.78
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-26,099,618.09	-9,675,855.78

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	953,369,500.00	1,027,774,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,200,000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,200,000.00	00.00
120009	Бусад орлого	1,200,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	952,169,500.00	1,027,774,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	952,169,500.00	1,014,274,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	952,169,500.00	1,014,274,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	13,500,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	10,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	3,500,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	940,802,190.00	1,017,723,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	940,802,190.00	1,017,723,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	932,284,485.29	964,214,715.00

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	736,307,238.29	759,374,430.00
210101	Үндсэн цалин	595,343,399.29	611,867,023.00
210102	Нэмэгдэл	93,466,555.00	99,031,949.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,636,000.00	24,336,000.00
210104	Урамшуулал	20,861,284.00	24,139,458.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92,237,800.00	95,306,030.00
210201	Тэтгэврийн даатгал	62,361,700.00	66,319,580.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,469,000.00	7,855,313.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,975,200.00	5,609,905.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,493,800.00	1,440,667.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,938,100.00	14,080,565.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,630,000.00	39,136,062.00
210301	Гэрэл, цахилгаан	4,984,609.00	4,555,650.00
210302	Түлш, халаалт	32,928,708.00	32,362,800.00
210303	Цэвэр, бохир ус	2,716,683.00	2,217,612.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,274,200.00	44,055,576.00
210401	Бичиг хэрэг	12,335,200.00	12,225,700.00
210402	Тээвэр, шатахуун	16,405,000.00	12,632,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,328,840.00	12,742,998.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	90,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,115,160.00	5,854,278.00
2105	Нормативд зардал	800,000.00	800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,232,230.00	6,812,980.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,557,580.00	713,180.00
210604	Урсгал засвар	11,674,650.00	6,099,800.00
2107	Томилолт, зочны зардал	5,094,150.00	5,078,000.00
210702	Дотоод албан томилолт	5,094,150.00	5,078,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,708,867.00	13,651,637.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	759,621.00	11,982,437.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	847,000.00	847,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	141,746.00	154,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	247,500.00	00.00
210807	Газрын төлбөр	369,000.00	323,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,517,704.71	53,508,685.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,990,000.00	3,968,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,990,000.00	3,968,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,527,704.71	49,540,685.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,527,704.71	49,540,685.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	12,567,310.00	10,051,500.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	12,567,310.00	10,051,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,567,310.00	10,051,500.00

2200	Дотоод эх үүсвэрээр	12,567,310.00	10,051,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12,567,310.00	10,051,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-12,567,310.00	-10,051,500.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	818,720,719.00	38,612,190.76	-247,354,994.28	609,977,915.48
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	818,720,719.00	38,612,190.76	-247,354,994.28	609,977,915.48
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-26,099,618.09	-26,099,618.09
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	818,720,719.00	38,612,190.76	-273,454,612.37	583,878,297.39
D01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	818,720,719.00	38,612,190.76	-273,454,612.37	583,878,297.39
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	818,720,719.00	38,612,190.76	-273,454,612.37	583,878,297.39
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-9,675,855.78	-9,675,855.78
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	818,720,719.00	38,612,190.76	-283,130,468.15	574,202,441.61

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,014,274,900.00	964,734,215.00	49,540,685.00	95.1

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,014,274,900.00	964,734,215.00	49,540,685.00	95.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,010,274,900.00	960,766,215.00	49,508,685.00	95.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	790,119,100.00	759,374,430.00	30,744,670.00	96.1
210101	Үндсэн цалин	646,703,900.00	611,867,023.00	34,836,877.00	94.6
210102	Нэмэгдэл	100,479,800.00	99,031,949.00	1,447,851.00	98.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,938,200.00	24,336,000.00	3,602,200.00	87.1
210104	Урамшуулал	14,997,200.00	24,139,458.00	-9,142,258.00	161.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,552,500.00	95,306,030.00	11,246,470.00	89.4
210201	Тэтгэврийн даатгал	74,947,700.00	66,319,580.00	8,628,120.00	88.5
210202	Тэтгэмжийн даатгал	7,901,200.00	7,855,313.00	45,887.00	99.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,321,000.00	5,609,905.00	711,095.00	88.8
210204	Ажилгүйдлийн даатгал	1,580,200.00	1,440,667.00	139,533.00	91.2
210205	Эрүүл мэндийн даатгал	15,802,400.00	14,080,565.00	1,721,835.00	89.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,530,000.00	39,136,062.00	393,938.00	99.0
210301	Гэрэл, цахилгаан	4,576,600.00	4,555,650.00	20,950.00	99.5
210302	Түлш, халаалт	32,362,800.00	32,362,800.00	00.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	2,590,600.00	2,217,612.00	372,988.00	85.6
2104	Хангамж, бараа материалын зардал	48,389,200.00	44,055,576.00	4,333,624.00	91.0
210401	Бичиг хэрэг	12,335,900.00	12,225,700.00	110,200.00	99.1
210402	Тээвэр, шатахуун	16,405,300.00	12,632,600.00	3,772,700.00	77.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,743,000.00	12,742,998.00	02.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	690,000.00	600,000.00	90,000.00	87.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,215,000.00	5,854,278.00	360,722.00	94.2
2105	Нормативд зардал	800,000.00	800,000.00	00.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	800,000.00	00.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,000,000.00	13,364,480.00	1,635,520.00	89.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	3,416,680.00	1,583,320.00	68.3
210604	Урсгал засвар	10,000,000.00	9,947,800.00	52,200.00	99.5
2107	Томилолт, зочны зардал	5,984,300.00	5,078,000.00	906,300.00	84.9
210702	Дотоод албан томилолт	5,984,300.00	5,078,000.00	906,300.00	84.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,899,800.00	3,651,637.00	248,163.00	93.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,177,900.00	1,982,437.00	195,463.00	91.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00	00.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	847,000.00	847,000.00	00.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	161,900.00	154,800.00	7,100.00	95.6
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00	00.00	100.0
210807	Газрын төлбөр	369,000.00	323,400.00	45,600.00	87.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,000,000.00	3,968,000.00	32,000.00	99.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,000,000.00	3,968,000.00	32,000.00	99.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.00	3,968,000.00	32,000.00	99.2
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,014,274,900.00	964,734,215.00	49,540,685.00	95.1

1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,014,274,900.00	964,734,215.00	49,540,685.00	95.1
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,014,274,900.00	964,734,215.00	49,540,685.00	95.1
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	38.00	38.00	00.00	100.0
620001	Удирдах ажилтан	05.00	05.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	29.00	29.00	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	04.00	04.00	00.00	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	38.00	38.00	00.00	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	16.00	16.00	00.00	100.0
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	12.00	12.00	00.00	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10.00	10.00	00.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		13,500,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		13,500,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		13,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		13,500,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		13,500,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	10000000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		10,000,000.00
131103	ЗГНХ, ЗДН Хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		10,000,000.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга М.Майжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газар нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 1/1134 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газар нь “Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Шүүхийн тухай хууль
- Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 906599.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 9066.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1058536.1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 21170.7 мянган төгрөгөөр тооцов.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 574282.4 мянган төгрөг болж өмнөх оноос 9595.8 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар тайлант оны үр дүнгээр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	30469.4	30517.1	47.7
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	80.1	80.1
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	30469.4	30437.1	-32.3
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	553408.8	543765.3	-9643.5
Үндсэн хөрөнгө	879902.6	910111.8	30209.2
Хуримтлагдсан элэгдэл	-37786.1	-39852.7	-2066.6
Нийт хөрөнгө	583878.2	574282.4	-9595.8
Өр төлбөр	0	80.0	80.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	583878.2	574282.4	-9595.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	583878.2	574282.4	-9595.8

Авлага дансанд өмнөх оны үлдэгдэл байхгүй бөгөөд тайлант онд цалингаас татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн тооцооллын зөрүүгээр шүүгч, ажиллагсадтай холбоотой 80.0 мянган төгрөгийн авлага үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 30437.1 мянган төгрөг болж 32.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 910111.8 мянган төгрөг болж 30209.2 мянган төгрөгөөр өссөн бөгөөд энэ нь Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 20157.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг шилжүүлэн авсан мөн тайлант оны батлагдсан төсвөөр 10051.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн 2020.08.17-ны өдрийн 03 тоот хурлын шийдвэр, 2020.10.29-ны өдрийн 05 тоот хурлын шийдвэр, 2020.11.05-ны өдрийн 06 тоот хурлын шийдвэр, 2020.12.21-ний өдрийн 07 тоот хурлын шийдвэрийг үндэслэн худалдан авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь дээд газраас үнэ төлбөргүй шилжиж ирсэн 20157.7 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 10051.5 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн ба тайлант онд үндсэн хөрөнгө актлаагүй байна.

Биет бус хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 64412.0 мянган төгрөг байсан өмнөх оноос 1000.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 1000.0 мянган төгрөгийн алдаа илрүүлэгч программыг шилжүүлэн өгсөнтэй холбоотой байна. Харин бөгөөд Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 574202.4 мянган төгрөг байна.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 1048860.3 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 91508.9 мянган төгрөгөөр буюу 8.7 хувиар өссөн байна.

Тайлант онд улсын төсвөөс 1014274.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, нэмэлт санхүүжилтээр, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс Төрийн албан хаагчдад орон сууц, хашаа байшин худалдан авахад олгосон санхүүгийн дэмжлэг 10000.0 мянган төгрөг, дээд газраас 3500.0 мянган төгрөгийн орлого орсныг бүртгэл тайланд бүрэн тусгасан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардал нь тайлант оны санхүүжилт 62105.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь НДШ-ын хувь хэмжээ нэмэгдсэн, ковид-19-тэй холбоотой бага үнэтэй түргэн элэгдэх зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлууд нэмэгдсэнтэй холбоотой байна. Үнэ төлбөргүй авсан орлого 21085.4 мянган төгрөг болж өмнөх оноос 17124.8 мянган төгрөгөөр өссөн нь дээд газраас шилжүүлж авсан хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээж авсан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Нийт зардал 1058536.1 мянган төгрөг болж өмнөх оноос 75085.1 мянган төгрөгөөр буюу 7.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь нэмэгдэл цалин, НДШ-ын зардал, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал, бичиг хэргийн зардал, шуудан холбооны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн бараа, ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлууд зардлууд нэмэгдсэнтэй холбоотой байна

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1120298.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1120298.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 88527.3 мянган төгрөгөөр хасагдаж 1031770.8 мянган төгрөгөөр анхны батлагдсан төсөв батлагдаж ирсэн бол 2020 оны 04 дүгээр сард өөрчлөлт орж 1066800.0 мянган төгрөг болж өөрчлөгдсөн, мөн оны 10 дугаар сард дахин өөрчлөлт орж 1166800.0 мянган төгрөг болсон ба 2020.12.31-ны байдлаар 1014274.9 мянган төгрөг болж төсвийн төслөөс 106023.2 мянган төгрөгөөр хасагдаж төсөв баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1014274.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 1014274.9 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1014274.9 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, урсгал үйл ажиллагаанд 964734,2 мянган төгрөгийг зарцуулж 49540.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 964734.2 мянган төгрөг буюу 95.1 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 30744.6 мянга, НДШ-ын зардлыг 11246.4 мянга, байр ашиглалттай холбоотой тогтол зардлыг 393.9 мянга, хангамж бараа материалын зардлыг 4333.6 мянга, эд хогшил урсгал засварын зардлыг 1635.5 мянга, томилот зочны зардлыг 906.3 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн зардлыг 248.1 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал 32.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 70701 хөтөлбөрийн 80101 арга хэмжээ 49540.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Хүснэгт 2. ТГ-ийн бүлэгтэй тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ХӨТӨЛБӨР 70701				
АРГА ХЭМЖЭЭ 80101				
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,014,274,900.00	964,734,215.00	49,540,685.00	95.12
УРСГАЛ ЗАРДАЛ	1,014,274,900.00	964,734,215.00	49,540,685.00	95.12
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,014,274,900.00	964,734,215.00	49,540,685.00	95.12
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	790,119,100.00	759,374,430.00	30,744,670.00	96.11
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,552,500.00	95,306,030.00	11,246,470.00	89.45
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,530,000.00	39,136,062.00	393,938.00	99.00
Хангамж, бараа материалын зардал	48,389,200.00	44,055,576.00	4,333,624.00	91.04
Нормативд зардал	800,000.00	800,000.00	0.00	100.00
Эд хогшил, урсгал засварын зардал	15,000,000.00	13,364,480.00	1,635,520.00	89.10
Томилолт, зочны зардал	5,984,300.00	5,078,000.00	906,300.00	84.86
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,721,900.00	1,669,200.00	52,700.00	96.94
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	0.00	0.00	0.00	
ХӨТӨЛБӨР 70701			0.00	
АРГА ХЭМЖЭЭ 80224			0.00	
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,177,900.00	1,982,437.00	195,463.00	91.03
УРСГАЛ ЗАРДАЛ	2,177,900.00	1,982,437.00	195,463.00	91.03
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,177,900.00	1,982,437.00	195,463.00	91.03
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,177,900.00	1,982,437.00	195,463.00	91.03
ХӨТӨЛБӨР 70701			0.00	
АРГА ХЭМЖЭЭ 80802			0.00	
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,000,000.00	3,968,000.00	32,000.00	99.20
Бусад урсгал шилжүүлэг	4,000,000.00	3,968,000.00	32,000.00	99.20
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж			0.00	
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.00	3,968,000.00	32,000.00	99.20

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус газрын нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс Төрийн албан хаагчдад орон сууц, хашаа байшин худалдан авахад олгосон санхүүгийн дэмжлэг 10000.0 мянган төгрөг, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 3500.0 мянган төгрөгийг тус газрын нэмэлт санхүүжилтийн 100030005401 тоот дансаар дамжуулан холбогдох зардалд нь зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 143 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулж, 6 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн ба хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9		2
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	4		
4	Сар бүр	5	36	36		
5	Тухай бүр	8	96	90	6	
	Нийт	29	151	143	6	2

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ыг хэрэгжүүлж ажиллах 1 зөвлөмжийн хэрэгжилтийг 2020.05.29-ны өдрийн 326 тоот албан бичгээр ирүүлсэн байна. Аудитаар өгөгдсөн зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2164.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил байхгүй болно.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 2164.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Тайлант онд НИК ХХК-аас 10070.0 мянган төгрөгийн шатахуун талон болон шатахуун худалдан авах карт цэнэглүүлсэн бөгөөд худалдан авалтад бэлтгэн нийлүүлэгчийн олгосон 302.1 мянган төгрөгийн хөнгөлөлт урамшууллыг шаардах болон замын хуудсаар зарцуулсан атлаа орлого, зардлыг бүртгэл тайланд тусгаагүй байна.

1.2. Эрсдэл: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.4 "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.5 бүх орлого, 14.4.6 бүх зардал" заалтыг тус тус зөрчсөн байна.

1.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.4 "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.5 бүх орлого, 14.4.6 бүх зардал" заалтыг хэрэгжүүлж, шатахууны урамшууллыг тухай бүр нь бүртгэж, тайланд бүрэн тусгаж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Тус байгууллага нь 2020.02.17-ны өдрийн 31 тоот төлбөрийн хүсэлтээр бичиг хэргийн зардлаас 262,6 мянган төгрөгийн шилжүүлэг хийлгэсэн байтал төрийн сангийн мэргэжилтэн тээвэр шатахууны зардлаас андууран гүйлгээг хийсэн байхад гарсан зөрчлийг арилгахгүй бүртгэл тайланд тусгасан байна.

2.2. Эрсдэл: Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2- д "Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар "Эдийн засгийн ангилал батлах тухай" тушаалын 6 дугаар хавсралтаар батлагдсан Тээвэр шатахуун" гэсэн төсвийн зарлагын ангиллаас гаргасан, "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.3. Өгсөн зөвлөмж: Цаашид батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гарсан алдаа зөрчлийг тухай бүр нь арилган бүртгэл тайланд үнэн зөв тусгах, холбогдох хууль журмыг мөрдөн ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Цалингийн зардлаас байгууллагын нэр бүхий 8 ажилтанд даргын 2020.12.21-ний өдрийн Б/30 тоот тушаалаар 1600.0 мянган төгрөгийн түлшний хөнгөлөлт олгосон байна.

3.2. Эрсдэл: Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2- д "Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар "Эдийн засгийн ангилал батлах тухай" тушаалын 6 дугаар хавсралтаар батлагдсан Тээвэр шатахуун" гэсэн төсвийн зарлагын ангиллаас гаргасан, "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.3. Өгсөн зөвлөмж: Цаашид цалингийн зардлыг зориулалт бусаар зарцуулахгүй, төлөвлөөгүй зардлыг санхүүжүүлэхгүй, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

П.АМАРЖАРГАЛ
ОГНОО: 2021.02.10

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН
МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ
ОГНОО: 2021.02.10

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ
ОГНОО: 2021.02.10



5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	Аудитын нэр:	Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:		
2020			БНА-2021/2/СТА-ТШЗ		
Шалгагдсан байгууллагын нэр:		Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газар	Мянган төгрөг		
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалыг зөрчиж цалингийн зардлаас байгууллагын нэр бүхий 8 ажилтанд даргын 2020.12.21-ний өдрийн Б/30 тоот тушаалаар 1600.0 мянган төгрөгийн түлшний хөнгөлөлт олгосон байна.	1265.0	Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	М.Майжаргал Б.Мөнхзул
2	Тайлант онд НИК ХХК-аас 10070.0 мянган төгрөгийн шатахуун талон болон шатахуун худалдан авах карт цэнэглүүлсэн бөгөөд худалдан авалтад бэлтгэн нийлүүлэгчийн олгосон 302.1 мянган төгрөгийн хөнгөлөлт урамшууллыг шаардах болон замын хуудсаар зарцуулсан атлаа орлого, зардлыг бүртгэл тайланд тусгаагүй байна.	302.0	Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	М.Майжаргал Б.Мөнхзул
3	Тус байгууллага нь 2020.02.17-ны өдрийн 31 тоот төлбөрийн хүсэлтээр бичиг хэргийн зардлаас 262,6 мянган төгрөгийн шилжүүлэг хийлгэсэн байтал төрийн сангийн мэргэжилтэн тээвэр шатахууны зардлаас андууран гүйлгээг хийсэн байхад гарсан зөрчлийг арилгахгүй бүртгэл тайланд тусгасан байна.	262.6	Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	М.Майжаргал Б.Мөнхзул
ДҮН		1820.6			

--oOo--